

XXI ЗУУНЫ БОСГОН ДЭЭРХИ ХЯТАД-ЭНЭТХЭГИЙН ХАРИЛЦАА

Л.БЭГЗЖАВ*

Хүн төрөлхтөн шинэ зуунд, шинэ мянганд дэвшин орлоо. XXI зуун бол үсрэнгүй хөгжлийн зуун байж, хүн төрөлхтөний нийгэмд гүн гүнзгий өөрчлөлт гарах зуун байх болно. Шинжлэх ухаан, техникийн дэвшил хурдсахын хэрээр дайны шинж чанар өөрчлөгдөж, интернетийн дайн, компьютерийн дайн, терроризм, түрэмгийлэл, электрон дайн, дайны гол үндсэн хэлбэр болж болзошгүй. Үүний зэрэгцээ хүн төрөлхтөний материаллаг соёл иргэншил урагшлах тусам, хүрээлэн байгаа орчны бохирдол, байгалийн гай гамшигийн уршгийг илүү амсаж эхэлнэ. Хүний нийгмийн урт удаан хугацаанд бүрэлдэн тогтсон үнэт зүйлс, үзэл онол шинэ зуунд, шинэ иргэншлийн цохилтонд өртөж хямралд орж, хүн төрөлхтөн шинэ үзэл бодлын эх сурвалжийг эрж хайх нь дамжиггүй.

Ийм дэлхий ертөнцөд улс хоорондын харилцаанд мөргөлдөөн, дайны голомт, шашин хоорондын зөрөлдөөн гарч улс орны бүрэн эрх зөрчигдөх явдал гарахгүй гэх газаргүй. Ялангуяа АНУ, Орос, Европын улсууд, Хятад, Япон зэрэг их гүрний хувь заяа хэрхэн өөрчлөгдөх, тэдний өөр хоорондын харилцаа, өрсөлдөөн ямараар эргэхийг ирээдүй судлаачид ч гэсэн төсөөлөхөд бэрх юм.

Дэлхийн улс хоорондын харилцаа, аюулгүй байдлын тухай ХХ зууны сүүлийн хагаст тогтсон аливаа онол номлол нэгэнт хуучирч, XXI зуунд эрс өөр огцом хүчин зүйл гарч болохыг АНУ-д энэ оны 9-р сарын 11-нд болсон хэрэг явдал харууллаа. Ардчилал, зөвшил гэрээ хэлцэлийн аргаас өөр, алан хядах, хүчээр түрээ барих, өшөө хонзон авах замаар дэлхийн шинэ дайн дэгдэж болох аюулын харанга дэлдлээ. Дэлхийн 30 гаруй орныг төлөөлсөн олон арван мянган хүн ажилладаг Нью-Йоркийн олон улсын худалдааны төв, АНУ-ын Батлан хамгаалах яамны төв байр Пентагоныг лалын шашинт алан хядагчид гэнэт довтолсон нь дэлхийг цочоож, улс төрчдийг алмайруулав. Үүний хариуд АНУ сөрөг цохилт хийх үйл ажиллагаанд алан хядагчдын эх орон төдийгүй энгийн номхон хүн ард, бүтээн байгуулалт, барилга орон байр өртөж буй нь, зөвхөн афганы алан хядагчдыг бус энгийн ард иргэдийг ч хамарч, улмаар дэлхий ертөнц дайны ирмэг дээр байна гэхэд хилсдэхгүй. Энэ үйл ажиллагаа хэдий хугацаагаар үргэлжилж, хичнээн хохирол, хэн хэндээ учруулахыг тааж хэлэхэд хэцүү юм. Хүчирхэг их гүрэн, бага

* Л.Бэгзжав. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

буурай орны тухай ойлголт ч хуучирч, шинэ техник технологи, мэдээлэл, мэдээллийн нууцлалд нэвтрэх шинэ арга зам хайх нь өнөөгийн дайн, сөргөлдөөний нэг гол шинж болж байна.

Ерөөс их гүрнүүдийн харилцаа бол дэлхийн стратегийн шинжтэй барометр, төдийгүй олон улсын харилцааны хандлагыг шийдвэрлэж, олон улсын стратегийн шинжтэй хөгжлийг бүхэлд нь тодорхойлж байна. Их гүрнүүдийн хоорондын хоёр талын харилцаа бол их гүрний харилцааг судлах зайлшгүй чухал судалгааны агуулга, үндсэн тулгуур мөн. Их гүрнүүдийн харилцааг олон давхаргат харилцаа гэж үзвэл хоёр талын харилцаа нь зөвхөн их гүрнүүдийн харилцааны нэг давхарга, нэг хэсэг юм. Ийм нэг давхарга, нэг хэсгийн нэг Хятад-Энэтхэгийн харилцаа ХХ зууны сүүлийн хагас, ХХI зууны босгон дээр хэрхэн өрнөж байгааг энд товч авч үзье.

х х х

Энэтхэг нь Хятадын баруун өмнөд хилд оршдог ойрын хөрш. Хоёр орон соёл иргэншил бүхий эртний улсууд, харилцааны 2000 гаруй жилийн түүхтэй. Хятад Энэтхэгийн хоорондын харилцаа Хятадын “Шиззи” (“Судар тэмдэглэл”) -д анх тэмдэглэгдсэн бол Энэтхэгийн эртний “Рамаяна”, “Махабрат” зэрэг номонд Хятадын холбогдолтой зүйлс тэмдэглэгдсэн байдаг. Хятадын торго зэрэг бараа Энэтхэгт нэвтэрч, Энэтхэгийн ноосон нэхмэл зэрэг бараа Хятадал орж байв. Энэтхэгээс эхтэй буддын шашин Баруун, Зүүн Хань улсын үед Хятадал нэвтэрч, Хятадын улс төр, эдийн засаг, соёл ч Энэтхэгт ихээр нөлөөлсөн юм Иймээс ч хоёр орны найрсаг харилцааг эрт дээрээс эх үндэстэй гэж хэлж болно.

Дэлхийн шинэ түүхэнд, Энэтхэг Английн колони орон байлаа. 1947 оны 8-р сарын 15-ны өдөр Энэтхэг улс тусгаар тогтнолоо зарлахаас өмнө Энэтхэг нь Пакистан, Бенгалийг нэгтгэсэн нэг улс байв. Английн колончилогчдын “хувааж, захир” гэдэг бодлогын уршигаар тус орон хоёр салсан юм. Үүнээс өмнө Англи Улс Энэтхэгийг 200 гарй жил ноёрхож байв.

Энэтхэг нь 2 сая 974700 км² газар нутагтай. Газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 7-рт ордог. Далайн эргийн урт нь 7600 км, Энэтхэгийн Андаман, Никобарын бүлэг арал нь Энэтхэгийн далайн зүүн хэсгийн усан хил болдог, стратегийн нэн чухал холбогдолтой газрууд юм. Нийтдээ 350 аралтай. Зарим нь эх газраасаа 1500 км зайтай. Энэтхэг нь хойгуураа өндөр уулархаг, өмнүүрээ өндөрлөг газартай, дунд хэсгээрээ тэгш талтай. Энэтхэгийн газар нутаг дэлхийн хуурай газрын 2,4%-ийг эзэлдэг.

Энэтхэгийн улс төрийн удирдагчид бүр тусгаар тогтнохоосоо өмнө тус орныг дэлхийн том гүрэн болно гэдэгт итгэж байв. Энэ нь

бүрэн утгаараа өнөө биелээгүй ч XXI зуунд ийм бололцоо их бий. Олон улсын нэлээд нэртэй улс төрчид ч ийм санааг олонтаа хэлсэн юм.

Америкийн ерөнхийлөгчийн аюулгүй байдлын зөвлөх асан З.Бженский “Агуу их шатрын хөлөг” номондоо Энэтхэгийг АНУ, Франц, Герман, Орос, Хятадын эгнээнд тавьж, дэлхийн стратегийн 6 том орны нэгд тооцсон байдаг.¹

АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан Генри Киссенжер үзэхдээ: “XXI зууны олон улсын системд... 6 гол хүчирхэг хүчин-АНУ, Европ Хятад, Япон, Орос, мөн Энэтхэг болоод хүчтэй дунд ба жижиг орнууд багтана”² гэжээ. XXI зууны олон улсын харилцаанд Ази тивийн гүйцэтгэх үүрэг тэр дундаа хил залгаа хөрш Хятад-Энэтхэгийн харилцаа онцгой үүрэг, ач холбогдол, нөлөөтэй байх нь тодорхой. Дэлхийд эртнээс эдүгээ хүртэлх соёл иргэншлийн цөм улс байсаар ирсэн Хятад-Энэтхэг улс нь олон мянган жилийн харилцааны түүхтэй билээ.

Энэтхэг, Хятад хоёр улс бол уул усаар холбогдсон байгаль газарзүйн холбоотой түүхэн уламжлалт харилцаатай орон хэдий ч улс төрийн өөрчлөлт, олон улсын харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан хоёр орны харилцаанд найрсаг сайхан, дайсагнасан харилцааны үе ч бас байсан. Энэ хоёр орон хүн ам, газар нутгийн хэмжээ, эдийн засгийн нөөц, дэлхийд болон Баруун өмнөд Азид эзлэх байр суурь, зарчим, цөмийн зэвсэг, соёл иргэншлийн нөлөө, компьютер, интернетийн сүлжээ болон газар зүй, стратегийн байрлалын давуу тал зэрэг олон олон онцлог шинжээрээ XXI зуунд дэлхийн том гүрний дотор жинтэй байр эзлэх нэн бололцоотой улсууд билээ.

Энэтхэг улс хүн ам, газар нутаг, эдийн засгийн хүчин чадал, дотоодын үйлдвэрлэлийг нийт өртөг, гадаад худалдааны хэмжээгээрээ Өмнөд Азийн бүс нутгийн 3/4 хувийг эзэлдэг.³ Цэрэг, шинжлэх ухаан, техникийн талаар Энэтхэг энэ бүс нутагтаа тэргүүлдэг.

БНЭУ бол дэлхийн их гүрнүүдийн хүчин чадлын тэнцвэрт чухал нэг хүчин зүйл, стратегийн ашиг сонирхлын зангилаа цэг юм. Хүйтэн дайны үед Энэтхэг улс ЗХУ-аас ч, АНУ-аас ч их хэмжээний эдийн засаг, цэргийн тусламж авч байлаа. Энэтхэг улс эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг санаачлагчийн хувьд гуравдагч ертөнцийн дотор олон улсын нэр хүнд, байр суурь сайтай байдаг.

Хүйтэн дайны үед ЗХУ-Энэтхэг хоёр “онцгой” харилцаатай байлаа. Энэтхэгийн зөвсгийн импортын бараг 80%-ийг ЗХУ-аас нийлүүлдэг байсан⁴ ба ЗХУ-ын тусламжтайгар батлан хамгалаах аж үйлдвэрийн системтэй болсон юм. 1971 онд хоёр орон “Энэтхэг-ЗХУ-ын энх тайван, найрамдлын гэрээ”-нд гарын үсэг зурж, их гүрний хооронд цэргийн холбоотны харилцаа тогтоож байсан нь Хятад-Зөвлөлтийн харилцаа муу байсан тэр үед Хятадын хувьд Энэтхэгээс

болгоомжлох арга хэмжээ авахад хүргэж байв. Хүйтэн дайны дараа хоёр орны харилцаа урьдынх шигээ биш боловч цэрэг, дипломатын салбарт нягт хамтран ажилласаар байгаа билээ.

Энэтхэгээс Хятадад хандах хандлага 2 талтай. Нэг талаар, Хятадад үл итгэх, урьдчилан хамгаалах сэтгэл зүй байсаар байгаа бөгөөд Хятадыг хамгийн их аюул занал учруулагч, стратегийн хувьд өрсөлдөгч гэж үздэг. Иймээс цөмийн зэвсгээ сайжруулж хөгжүүлэх нь Хятадтай хүчний тэнцвэр хадгалах гэсэн хэрэг гэж Энэтхэгт үздэг. Нөгөө талаар, Хятад, Энэтхэг хоёул цэргийн мөргөлдөөнөөс зайлсхийж, хоёр орны харилцааг хэвийн болгож, сайн хөршийн найрсаг харилцаа тогтоохыг эрмэлзэж байна. Энэ бол хоёр орны үндсэн эрх ашиг нийлж буй уулзвар юм. Хятад-Энэтхэг хоёр улс дэлхийн хамгийн том хөгжиж буй орнууд, олон улсын томоохон чухал олон асуудал дээр адил буюу төстэй байр суурь баримталдаг.

х х х

БНХАУ бол 9,6 сая км² газар нутагтайгаараа дэлхийд ОХУ, Канадын дараа 3 дугаарт ордог бөгөөд энэ нь хуучны ЗХУ-ыг үл оролцуулан Европын 34 орны нутаг дэвсгэртэй бараглан тэнцүү буюу Энэтхэгээс 3 дахин, Францаас 18 дахин, Японоос 25 дахин том гэсэн үг.

БНХАУ бол дэлхийн хүн амын 23%-ийг хооллож, хувцасладаг том орон, хүн амын тоо нь эдүгээ 1,2 тэрбум даваад байгаа, 5000 жилийн түүх, соёл иргэншилтэй, өвөрмөц онцлогтой том гүрэн.

НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн Байнгын 5 гишүүний нэг, БНХАУ нь дэлхийн цөмийн зэвсэгтэй их гүрний нэг, сансрын техник эрчимтэй хөгжиж буй цөөн орны нэг юм.

XXI зууны хувирал өөрчлөлтийг хүн төрөлхтөн ямараар төсөөллөө ч шинэ зуунд олон улсын харилцаанд ихээхэн хувирал, шинэ үйл явдал олон гарах нь дамжиггүй. Ялангуяа XXI зууныг олонхи судлаачид “Азийн зуун”, тэр дундаа “Хятадын зуун” болно гэдэгтэй санал нэг байдаг. БНХАУ шинэ зууны дунд үе гэхэд дэлхийн хүчирхэг, баян, тэргүүний хөгжилтэй их гүрэн болох зорилт дэвшүүлээд, энэ чиглэлээр итгэлтэй урагшилж байна.

“Нэг улс-хоёр нийгмийн байгуулал” гэдэг зарчмын үндсэн дээр Хятад улс XXI зууны босгон дээр Англи, Португали улстай хэлэлцэн тогтсоны үндсэн дээр Гонконг, Макао-г эх орондоо нэгтгэх асуудлыг амжилттай шийдвэрлэлээ. Энэ зарчмыг удирдлага болгон Тайванийг асуудлыг ч шийдвэрлэхийг чармайж байна.

Олон улсын байдал, Хятадын дотоодын хэрэгцээ шаардлагыг үндэслэн БНХАУ энх тайван, хөгжлийн чиг баримжааг удирдлага болгон улс хоорондын дипломат бодлого, олон улсын харилцаагаа өргөжүүлэх

идэвхитэй гадаад бодлого явуулж байна. Ялангуяа хөрш орнуудтайгаа маргаантай асуудлыг зохицуулах, найрамдал хамтын ажиллагаагаа өргөтгөх, дэлхийн том гүрнүүд ОХУ, АНУ, Япон, Энэтхэг зэрэг орнуудтай олон улсын тавцанд тэнцвэр барих, идэвхитэй хамтран ажиллах бодлого баримталж байна.

Одоо Энэтхэг улс нь хөгжиж буй орнуудын дотор хөгжлөөрөө ганцхан Хятадын дараа орж, тэр ч байтугай олон талаар Хятадыг давж гараад байна. Энэтхэг улс эдийн засгийн гол үзүүлэлтээрээ дэлхийд эзлэх байр суурь нь гэвэл:

№	Үзүүлэлт	Нэгж	Дэлхийн дүн	Энэтхэг	Дэлхийд эзлэх байр
•	Газар нутаг	Сая км ²	133,5	3,3	7
•	Хүн ам	Сая	5829	948	2
•	Дотоодын нийт бүтээгдэхүүн	100 сая ам. доллар	28157	360	15
•	Хөдөө аж ахуйн нэмэгдсэн өртөг	100 сая ам. доллар		97,2	5
•	Үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг	100 сая ам.доллар		68,4	14
•	Цахилгаан гаргалт	100 сая квт	12028	435	8
•	Бараа үйлчилгээний экспортын хэмжээ	100 сая ам.доллар	6689	42,7	30
•	Хагалсан талбай	Сая.га	1476	170	2
•	Усалгаатай талбай	Сая.га	255,5	50,1	1
•	Тугарга хураалт	Сая.т	562	120	2
•	Арвай хураалт	Сая.т	585	63	2
•	Үнээний сүү үйлдвэрлэлт	Сая.т	518,2	65,0	2

Тайлбар: Хүснэгт дээрх тоо бол 1994-1997 оны тоо бүртгэлийн мэдээ ба Энэтхэгийн тоон үзүүлэлтийн ихэнхийг тус улс НҮБ ба Дэлхийн банкинд гаргаж өгсөн тоо юм⁵.

1995 онд Энэтхэг улсын нийт бүтээгдэхүүний өртөг АНУ-ын 1/20 (6952 тэрбум ам доллараар дэлхийд 1-рт), японы 1/15 (5108,5 тэрбум ам доллараар дэлхийд 2-рт), Хятадын 1/2 (694,6 тэрбум ам доллараар дэлхийд 7-рт орж байв⁶)

Гэвч худалдан авах чадвараар дэлхийд 5-рт ордог байна.

Энэтхэг улс одоо компьютерийн программ хангамж экспортлодог дэлхийн гол орон бөгөөд дэлхийн хамгийн том 500 үйлдвэрийн талаас илүү нь энэтхэгийн компьютерийн програмын

хангамжийн үйлчилгээг ашиглаж байна. Энэ үйлчилгээ 1992\1993 онд 7,4 тэрбум рупи байсан бол 1996\1997 онд 41 тэрбум 130 сая рупи, 1997\1998 онд 65 тэрбум болон өсч 5 жилд 8,78 дахин өсчээ⁷. Энэтхэгийн засгийн газар ойрын 10 жилд энэ үзүүлэлтийг 500 тэрбум рупид хүргэхээр төлөвлөж байна.

Сүүлийн хэдэн арван жилд Энэтхэгт “ногоон хувьсгал” (үр тарианы үйлдвэрлэл), “Цагаан хувьсгал”-ыг бүх талаар өрнүүлж бодитой амжилтанд хүрсэн байна. Одоо тус улс “мэдээллийн технологийг нэвтрүүлэх төлөвлөлгөө”-г (Information Technology Action Plan) төлөвлөн хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөлгөө бол Энэтхэгийн XXI зуунд хөтлөн удирдах чухал хөтөлбөр болох юм.

БНЭУ бол хуурай замын цэргийн тоогоороо дэлхийд 4-рт, дэлхийн 6 дахь цөмийн зэвсэгтэй улс, шинжлэх ухаан техникийн ажилтаны тоогоор дэлхийд 3-рт ордог, тоо нь цөөн боловч агаарын нисэх хүчний чадал нь дэлхийн хэмжээнд, электрон тооцоолон бодох, мэдээллийн сүлжээ нь бүх дэлхийд тархсан орон юм.

х х х

Энэтхэгийн хүн ам нь хурдан өсч, хүн амынхаа тоогоор дэлхийд Хятадын дараа орох том орон бөгөөд эдүгээ 1 тэрбум даваад байгаа нь дэлхийн хүн амын 16 хувийг эзлэж байна. Тус орны хүн амын өсөлт жил бүр 15,5 саяар нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурдаараа олныг цочроож байна. 2045 он гэхэд Энэтхэг хүн амаараа Хятадаас давж хүн ам хамгийн ихтэй улс болох төлөвтэй байна.

XX зуунд дэлхийн хүн ам 2 тэрбумаас 6 тэрбумд хүрч, 3 дахин өссөн бол Энэтхэгийн хүн ам 4 дахин өсч 238 саяас 1 тэрбум болжээ. 1901 онд Энэтхэг улс 238 сая хүнтэй байснаа 1961 онд 439 сая, 1991 онд 846 сая, одоо 1 тэрбум даваад байна⁸. Хэрэв хүн амын төрөлтийн талаар тодорхой арга хэмжээ авахгүй бол хүн амын асуудал тус орны хамгийн ноцгой хүнд асуудал болж, эргэн тойрны улс орон, дэлхийн хөгжилд ч нөлөөлж болзошгүй гэсэн болгоомжлол байдаг. Хүн ам нь эрс өсч буй нь газар нутаг, үр тариа, орон сууц, усан хангамж, боловсрол, ажилгүйдэл зэрэг энэтхэгчүүдийн толгойг өвтгөсөн олон асуудлыг бий болгож байна.

Үнэндээ бол тус орон 1952 оноос төлөвлөгөөт төрөлтийн арга хэмжээ авч, нийгмийн эрүүл ахуй, сургалтын үнэгүй систем тогтоосон боловч хүн амын өсөлтөө тогтоож дийлээгүй байна. 1952 оноос хойш Энэтхэгийн хүн амын үхэл багассан ч төрөлтийн хувь буураагүй байна. 1976 онд тус улсын залуучуудын гэрлэх насыг 18 байсныг 21 болгож, төрөлтийн хэмжээ тогтоож, үр хөндөх хатуу дэглэмд орсон хэдий ч санасан үр дүнд хүрээгүй юм. Ихэнхи нутаг оронд нь харьцангуй ядуу,

хүмүүсийн үзэл ухамсар бас ч хоцрогдмол байдаг нь дээр дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүндрэл гаргаж, ялангуяа хоцрогдмол тосгон сууринд албан түшмэдүүдийн дарамтаас болж, нийгмийн зүгээс эсэргүүцэл гарч байв. Бараг бүх тосгоны 74 хувь нь зам харилцаа, мэдээлэл хомс учраас хүн амыг төрөлтөөс сэргийлэх зэрэг арга хэмжээ авахад бэрхшээл учруулж байв. Энэ нь олон жилийн турш Энэтхэгийн хүн амын хурдан өсөлтийн шалтгаан болж байлаа.

Хүн ам хязгаарлах бодлого нь эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн тодорхой нөхцөлийг багагүй шаарддаг. Тус орны засгийн газраас хүн амын төрөлтийг хязгаарлах “Улсын хүн амын бодлого-2000” гэсэн төсөл баталж төлөвлөгөөтэй төрсөн эмэгтэйчүүдийг урамшуулан шагнах, өрх гэрийн амьдралыг дээшлүүлэхийн тулд эрүүл мэндийн даатгал хэрэглэх болов. Мөн “хүн амын улсын хороо” гэсэн тусгай байгууллага байгуулж, орон нутагт салбар хороод байгуулан энэ ажлыг удирдан хянан шалгаж байхаар болгов. Тус орны засгийн газраас төлөвлөснөөр 2010 онд Энэтхэгийн хүн амын өсөлтийг 1,1-1,2 хувь хүртэл бууруулахаар төлөвлөж байгаа ч эцсийн эцэст хүн амын өсөлт нь Хятадаас давж гарахаар байгаа аж.

Энэтхэгт 900 сая хүн индуизмын (энэтхэгийн) шашныг шүтдэг, 100 сая хүн лалын шашныг, 20 сая хүн сикхизм, 20 сая хүн христос шашин шүтдэг байна.

Энэтхэгчүүдийн дунд кастын систем буюу анги бүлэг болгон зэрэг дэв тогтоох ёс амь бөхтэй хэвээр байна. 3000 жилийн түүхтэй энэ ёсоор хамгийн дээд хүмүүст брахман, түүний дотор лам хувраг, сэхээтэн ордог. Дараа нь буддист, цэргийнхэн, тариачид, худалдаачид, эцэст нь ажилчид урчууд буюу дээдсийнхний хэрэглээний хүмүүс ордог байна.

Энэтхэгийн нийгмийн хамгийн доод давхрага бол “эгэл доордос” гэгдэх 35 сая ядуус юм. Кастын системд хамрагддаг хүмүүс доордосоос илүү бөгөөд кастын асуудал нь энэтхэгийн хөгжлийн чухал асуудлын нэг юм.

х х х

Эртнээс Энэтхэгчүүд Америкт амьдарч, сурах гэж өрсөлдөж ирсэний дотор 1 сая гаруй хүн Америкийн харьяат болжээ. Америкийн харьяат энэтхэгчүүдийн дотор 300 мянга нь шинжлэх ухаан техникийн дээд зэрэглэлийн компанид ажилладаг ба 1999 онд тэдний орлого 60 тэрбум ам.долларт хүрч байжээ. 10 жилийн өмнө америкийн харьяат энэтхэгчүүдийн орлого 60 мянган доллар байсан нь Азиас нүүж очигсодоос хамгийн өндөр нь байжээ. Тэднээс 80-100 мянган хүн

Вашингтонд тансаг хороололд амьдардаг.

Энэтхэгчүүд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар асар хүчтэйгээ харуулаад зогсоогүй улс төрийн талаар ч амаргүй хүмүүс болохоо үзүүлжээ. Тэд америкийн улс төрд идэвхитэй оролцож, АНУ-аас Энэтхэгийн талаар явуулах бодлогод хүчтэй нөлөөлдөг. Тэдний бараг 40 хувь нь АНУ-ын сонгуульд мөнгө зарж, Ардчилсан нам, БН намын хүмүүсийг дэмжиж, АНУ, Энэтхэгийн харилцааг сайжруулахад санал бодлоо илэрхийлдэг байна. Тэд Энэтхэг-Пакистаны мөргөлдөөнд АНУ-ын гадаад бодлогыг Энэтхэгийн талд хандуулж чадсан билээ. Америкийн энэтхэгчүүд улс төрийн нөлөөгөө ашиглан Пакистаныг эрс шүүмжилж байв. Тэд Америкийн сенатад факс, цахилгаан олноор явуулж, утсаар ярьж, өөрсдөө уулзах зэргээр ихэд нөлөөлж Америкийн сенатаар Пакистаныг буруушсан тогтоол гаргуулж байв. Тэд эдийн засгийн хүчин чадлаа улс төрд зориулж, эх орныхоо төлөө хүчин чармайлтаа зориулж байлаа. Ерөнхийлөгч Б.Клинтоныг 2000 оны 3-р сард Энэтхэгт айлчлахаас өмнөхөн Клинтонор Энэтхэгийн ажилчдыг гадаадад гарах визийн зөвшөөрөл гаргуулж байв. Одоо тэд Америкийн нийгэмд харьцангуй хүчтэй нийгмийн бүлэг болж гараад байна.

Тэд Энэтхэгийн эдийн засгийн бүтээн байгуулалтанд ихээхэн хувь нэмрээ оруулдаг байна. Америкжсан энэтхэгчүүд жилд дунджаар 2 тэрбум долларыг Энэтхэгийн шинжлэх ухаан, техникийг хөгжүүлэхэд зориулдаг аж. Америкийн энэтхэгчүүд энэтхэгийн шинэчлэлийн үйлсэд багагүй хувь нэмрээ оруулж байна. Ялангуяа Хятад-Энэтхэгийн харилцааны тал дээр тэд ихэд анхаарч нөлөө, үүрэгтэй байдаг юм. Америкийн зарим стратегчид Азид Хятадын нөлөөлөх хүч өсөж байгаа тул үүнийг тэнцвэржүүлэхийн тул Энэтхэгийг улам бүр илүү анхаарч байна. АНУ-ын энэтхэгчүүд ч энэ асуудалд ихээхэн ач холбогдол өгдөг. Америкчууд Хятадыг хязгаарлан барих бодлогодоо энэтхэгчүүдийн нөлөөг ашиглахыг чармайж байна.

х х х

Энэтхэг өнөө компьютерийн том орон болоод зогсоогүй энэ талаар супер хүчирхэг орон болоод байна. Программ хангамжийн мэргэжилтэний тоо, ашиглаж буй байдал, компьютерийн сүлжээ зэргээрээ Энэтхэг улс дэлхийд манлайлах байр суурьтай байна. 1990-ээд онд Энэтхэгийн компьютерийн хөгжлийн өсөлтийн түвшин 59 хувьд хүрч, 1990 оны өмнөхөөс 20 сая ам.доллар болсон бол 1999 онд 4 тэрбум долларт хүрч, 10 жилд 200 дахин өсөв. Компьютерийг 90 гаруй оронд экспортлодог бөгөөд энэ нь жил бүр 1 тэрбум долларт хүрч байна. 10 жилийн дараа Энэтхэгийн мэдээллийн үйлдвэрлэл өнөөгийн 5 тэрбум доллараасаа 100 тэрбум долларт хүрэх ажээ. Калифорний

шинээр байгуулагдсан 2000 компаний 800-г нь энэтхэг хүмүүс эрхэлж байна. Мэдээллийн технологид оруулж буй хөрөнгө оруулалтын 15 хувийг энэтхэгийн хөрөнгө оруулалт эзлэж байна. Америк жил бүр Энэтхэгээс их хэмжээгээр технологийн мэргэжилтэн урьж аваачдаг бөгөөд тэдний 46 хувь нь АНУ-д үлдэж ажилладаг ажээ⁹. Энэтхэгийн программист М.К.Сингт “Зуун жилийн өмнө англичууд энэтхэгийн цэргийн хүчинд дулдуйдан дэлхийд ноёрхож байсаны нэг адил, өнөөдөр АНУ Энэтхэгийн зохион бүтээх хүч, хүчирхэг дэмжлэгтэйгээр улс орныхоо мэдээлэл хангамжийг хөгжүүлж, улмаар олон улсын зах зээлийг атган барьсаар байна¹⁰ гэж хэлсэн нь нэн сонирхолтой юм. Өнөө Энэтхэг улс тооцоолон бодох программ хангамжийн үйлдвэрлэлээр дэлхийд АНУ-ын дараа орох болов. 1999-2000 онд Энэтхэгийн энэ талын үйлдвэрлэл 5,65 тэрбум ам.доллар хүрчээ. Программ хангамжийн экспорт Энэтхэгийн экспортын 10,5 хувь байгаа ба 2003 онд 23 хувь болох аж¹¹.

1990 оны эхээр Энэтхэгийн засгийн газар тооцоолон бодох программ зохиох технологийн бүс байгуулж, хөгжлийн урт хугацааны стратеги боловсруулав. Засгийн газраас энэ салбарт давхар татвараас чөлөөлөх, гадны 100 хувийн хөрөнгө оруулалттай компани байгуулахыг зөвшөөрөв. Дэлхийн олон орны мэдээллийн технологийн компаниуд шиг Энэтхэг иймэрхүү компани, судалгааны төв байгуулав. Энэтхэгт үнэхээрийн мэдээллийн хувьсгал өрнөж, Ф.Беконь “мэдээлэл эзэгнэгч нь дэлхийг эзэгнэгч болно” гэж 400 жилийн тэртээ хэлсэн үгийг амьдралд бодитой болгож байна. Түүхэнд Хятад, Энэтхэг хоёр урт хугацааны найрсаг харилцаатай явж ирсэн ч Хятад, Энэтхэгийн 1959 оны хилийн мөргөлдөөнөөс хойш, Энэтхэгт ч, Хятадад ч энэ асуудалд сэтгэл зовсоор байгаа юм. 1998 онд Энэтхэг улс цөмийн зэвсэг туршсанаас хойш Хятадад түгшүүр төрсөн бөгөөд Хятад ч цөмийн зэвсэгтэй гүрэн билээ.

Хятад улс Пакистан, Энэтхэг хоёртой хил залгаа болохоор Кашмирын асуудлаархи Пакистан-Энэтхэгийн мөргөлдөөн Хятадад нөлөөлөх нь ойлгомжтой. Пакистаны засаг захиргааныхан 2000 оны 1-р сард Хятадад айлчилж, Хятадын удирдагчидтай Кашмирын асуудлыг хэлэлцсэнийг Энэтхэгийн тал мэдээж таатай хүлээж аваагүй бөгөөд Энэтхэгт “Хятадыг бүслэх стратеги” хэрэгтэй гэж мэдээлж байв. Тэд Хятад, Пакистаны харилцаа хэвийн болоход болгоомжлон хандаж байгаа юм. Зарим хэвлэлд “Энэтхэг улс томоохон стратеги боловсруулж Хятад, Пакистаны харилцааг таслах хэрэгтэй” гэж бичиж байв. Энэтхэг улс шинэ түнш АНУ, Япон, Индонез, Малайз зэрэг улстай Энэтхэгийн аюулгүй байдлын асуудлаар “Хятадыг бүслэх стратеги” боловсруулав.

санаатай байна гэж Хятадад үзэж байна. Хятад улс өөрсдийгөө Энэтхэгт ямар ч аюул учруулаагүй. Бид бүтээн байгуулалтанд анхаарал хандуулж байна. Харин зарим хүмүүс Хятадад аюул учруулах санаархалтай байж магад хэмээн үзэж байна. 2000 оны 3-р сард Энэтхэгийн улс төрийн судалгааны төвийн нэгэн эрдэмтний өгүүлэлд Энэтхэг-Америкийн шинэ холбоо байгуулах, Хятадыг хязгаарлах тухай өгүүлжээ. Тэрээр АНУ, Энэтхэг хоёр Азид аюулгүй байдлын шинэ холбоо тогтооход шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд голлох ардчилсан орнууд болох Энэтхэг, Япон, БНСУ, Филиппин, Тайланд, Индонез зэрэг орнууд эдийн засаг, улс төрийн талаар улам илүү хамтран ажиллаж, хятадын хүчин чадал өсөхийг хязгаарлах хэрэгтэйг дурьджээ. Ингэхдээ дээрх орнууд Хятадтай “хязгаарлахын” зэрэгцээ ойртох бодлого баримтлаж, цэргийн хүчээ зузаатгаж, Хятадыг “өргөжин тэлэхээс” болгоомжлох ёстойг дурьджээ. Түүний үзсэнээр АНУ, Энэтхэг хоёр тодорхой хугацаанд “ардчилсан улсуудын” тэргүүн нарын уулзалт хийж, хамтаар Хятадыг “хязгаарлах” арга хэмжээ авбал зохино гэжээ. Эл өгүүлэл Б.Клинтон Энэтхэгт айлчлах үеэр хэвлэгдсэн нь АНУ-ыг Хятадын эсрэг хандуулах гэсэн оролдлого гэж Хятадад үзэж байна.

Энэтхэг үнэхээр “Хятадыг бүслэх стратеги” баримтлах уу? Энэтхэг АНУ-ын харилцаа илт идэвхжиж, Энэтхэг, Япон хоёр 2000 оны эхээр аюулгүй байдлын асуудлаар яриа хэлцэл хийж, Энэтхэг Зүүн өмнөд Азийн улсуудын харилцаа тасралтгүй сайжирч, 2000 оны эхээр Энэтхэгт Вьетнам, Сингапур, Индонез, Кампучи зэрэг орны удирдагчид айлчилж, Энэтхэг-Мьянмагийн цэргийн удирдах болон засгийн газрын гишүүд 2000 оны эхээр харилцан айлчилсан, Энэтхэг-Орос хоёр уламжлалт найрсаг харилцаатай, хоёр тал түншлэлийн харилцаагаа зузаатгаж байна.

Мөн Энэтхэг Оросоос их хэмжээний зэвсэг худалдан авсаны дотор дэлхийн шилмэл танк болох Т-90 банк 300 гаруй, шумбагч усан онгоц, МИ-29 бөмбөгдөгч онгоц авахад 800 сая доллар зарцуулжээ.

Энэтхэг улс АНУ болон бусад орноос зэвсэг импортлож, агаарын зэвсэгт хүчний их хэмжээний зэвсэг авахаар болж, 2000 оны зэвсэгт хүчний зардлаа 28 хувиар нэмэгдүүлж, Энэтхэг-Хятадын хилийн районд цэрэг суулгаж, 1999 онд 50000 цэрэгтэй шинэ корпус байгуулав¹². Үүний зэрэгцээ Энэтхэг 2001 оны эцсээр өмнө далайн хилээ өргөтгөхөөр бэлтгэж, далайн хилээ 200 далайн миль-ээс (далайн 1 миль=1852м) давуулах, 2000 оны 4-р сард Энэтхэгийн далайн цэргийн сургуулийг өмнөд Хятадын тэнгист хийж, мөн оны 10, 11-р сард БНСУ, Вьетнамтай тус тус хоёр талын цэргийн сургуулилалт хийв.

Иймд Хятад сонор сэрэмжтэй байх, дайн дэгдээхээс сэрэмжилэх хэрэгтэй. Эс тэгвэл хоёр орны харилцаа муудах төдийгүй Азид тогтворгүй, аюултай байдал үүсч магадгүй гэж Хятадууд үзэж байна.

х х х

БНХАУ, БНЭУ 1950 оны 4-р сард албан ёсны дипломат харилцаа тогтоож, 1954 оны 4-р сарын 29-нд “Хятадын Төвд ба Энэтхэгийн хооронд худалдаа, тээвэр хийх тухай хэлэлцээрт” гарын үсэг зурж, 1954 оны 6-р сарын 22-нд гаргасан Хятад, Энэтхэгийн “хамтарсан албан мэдээ”-нд энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг тодорхойлж, хоёр орны тэгш эрхтэй, харилцан ашигтай байх үндсэн дээр хоёр талын нягт харилцааг бий болгон, хөгжүүлэхийг онцлон тэмдэглэжээ. 50-иад оны сүүлч, 60-аад оны эхээр Хятад-Энэтхэгийн хооронд хилийн мөргөлдөөн гарч, хилийн дайн болтол өргөжсөнөөр хоёр орны харилцаа ноцтой муудсан юм. 70-аад оны дунд үеэс хойш, тухайлбал 1976 онд харилцан элчин сайдаа солилцон суулгаж дипломат харилцаагаа сэргээж, дараагаар нь ГЯЯ-ны орлогч сайд нарын хэмжээнд яриа хэлэлцээ хийж эхэлснээр хоёр орны харилцаа намжмал, харилцан ойлголцох чиглэлээр хөгжих болов. 1988 оны эцсээр Энэтхэгийн ерөнхий сайд Ражив Ганди Хятадад айлчилж хоёр орны харилцаа сайжран, улс төр, эдийн засаг, соёл болон бусад салбарын солилцоо, хамтын ажиллагаа өргөжиж, хоёр талын удирдагчдын харилцан айлчлал олширч, цэргийн салбарт итгэлцэл бэхжиж, хилийн асуудал намжиж, олон улсын тавцан дээр ч хамтран ажиллах боллоо.

1993 оны 9-р сард Энэтхэгийн ерөнхий сайд Рао Хятадад айлчлан, “Хятад-Энэтхэгийн хилийн бодит хязгаарлалтын шугам ба энх тайван аюулгүй байдлын хэлэлцээрт” гарын үсэг зурлаа. 1996 оны 12- сард БНХАУ-ын дарга Зянь Земинь Энэтхэгт айлчилж, хоёр тал “Хятад-Энэтхэгийн хилийн бодит хязгаарлалтын шугамын нутагт цэргийн салбарт итгэлцэл бий болгох арга хэмжээний хэлэлцээр”-г гарын үсэг зурав.

1998 оны 12-р сард ОХУ-ын Ерөнхий сайд Е.Примаков Энэтхэгт айлчилахдаа орос-хятад-энэтхэгийн хооронд “стратегийн гурвалжин” байгуулж, АНУ-ын дэлхийд ганцаар хэт их гүрэн болох санаархалыг эсэргүүцэж, тэндвэр барих тухай санал дэвшүүлсэн юм¹³. Энэ санал нь өмнөд Ази дахь АНУ-ын эрх ашгийг хөндөж байгаа гэж америкийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгарав. Нөгөө талаар Орос-Хятадын стратегийн түншлэл, Орос-Энэтхэгийн стратегийн түншлэлийн харилцааг 3 талын болгох саналд энэтхэг, хятад ч нааштай хандаагүй нь Энэтхэг-Хятадын харилцаатай холбоотой юм.

1998 онд Энэтхэг улс 5 удаа цөмийн зэвсэг амжилттай туршсаны дараа Энэтхэгийн үндэсний конгресс намын удирдагчид хятадыг “тэргүүн зэргийн аюул заналхийлсэн улс”¹⁴ гэж нэрлэх болсоныг гадаадын тоймчид тэмдэглэж байв. Хятад улс 1960-аад онд цөмийн зэвсэгтэй болсон нь Энэтхэгт аюул учруулж байна гэж Энэтхэг үзэх болсон юм. Хятад улс цөмийн зэвсэгтэй болсоныгоо АНУ, ЗХУ-ын цөмийн монополийг таслан зогсоохын төлөө юм гэж үзэж байв. Энэтхэгт “хятадын цөмийн аюул”-ын тухай байнга ярих болж, эндээс үүдэн цөмийн зэвсгийн асуудал бол хятад-энэтхэгийн хооронд бас нэн ноцтой асуудал гарч байна. Урьд нь хоёр орны хооронд төвдийн асуудал, хоёр талын хилийн маргаан, хятад-пакистаны харилцааны асуудал зэрэг асуудал байсан юм.

Хятад Энэтхэгийн харилцаанд санал нийлэх, эс нийтлэх асуудал цөөнгүй, Санал зөрөлдөөнтэй тал дээр бодит байдлыг үндэс болгож, зөрчилдөөнийг хамтын эрх ашиг нийлсэн салбарт нөлөөлөхгүй байлгах, тодорхой нөхцөл бүрэлдсэний дараа энэ асуудлыг дахин шийдвэрлэж болох юм гэдэгт хоёр тал санал нийлж байна. Энэ бол Энэтхэгийн ерөнхий сайд Рао 1993 оны 9-р сард Хятадад айлчилахдаа хэлсэнчилэн Хятад-Энэтхэгийн “боловсорч буй харилцаа” юм.

1999 оны 7- сард Энэтхэгийн ГЯЯ-ны сайд Ж.Сингх Хятадад айлчилах үеэр хоёр тал энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим бол хоёр орны харилцааг чиглүүлэн залагч зарчим мөн гэдгийг харилцан хүлээн зөвшөөрөв. БНХАУ-ын дарга Зянь Зэминь Энэтхэгт хоёрдахь удаагаа айлчилсаныг хоёр улсын харилцаанд шинэ хувь нэмэр оруулсан чухал үйл явдал гэж хоёр тал үнэлсэн бөгөөд хоёр орны харилцаа үеийн үед найрсаг байх ёстой гэж БНХАУ-ын дарга тэмдэглэн хэлж байв. БНХАУ-БНЭУ-тай сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэх явдал бол Хятадын гадаад бодлогын нэн чухал асуудлын нэг гэж үздэг юм¹⁵.

XX зууны сүүлийн хагаст Хятад-Энэтхэгийн харилцаа ерөнхийдөө нэгэн жигдгүй, сайдаж, муудаж, дардан бус замаар явж ирлээ. Хүн төрлөхтөн XXI зуунд дэвшин орсон энэ цаг үед хоёр орны харилцааны өнгөрсөн түүх өөрчлөгдөж, их хувирал өөрчлөл гарах нь магад. Хамгийн гол нь өнгөрсөн 50 жилийн харилцааны түүхэн сургамж нь “хятад-энэтхэг эртний бөгөөд урт удаан хугацааны харилцаа”-тай байсан юм гэсэн үзэл бодлыг; хоёр орны харилцааг 50-аад оны түвшинд хүртэл дахин сэргээх хэрэгтэй; “хятад-энэтхэгийн хооронд үндсэн ноцтой зөрөлдөөн байхгүй” гэсэн өөдрөг үзэл бодолд хоёр тал санал нэгтэй байгаа явдал юм.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. З.Бженский “Великая шахматная доска” М., 1999, стр....
2. Henry A.Kissinger, Diplomacy, New York; Simon & Schugtrre, 1994; pp.23-24
3. “Иньду дэ фачжан цзи чи дуйвай чжанлю”, (Энэтхэгийн хөгжил хийгээд гадаад бодлогын стратеги), Ерөнхий редактор Сун Шихай. Хятадын нийгмийн шинжлэх ухааны хэвлэлийн хороо, Бээжин, 2000, 314-р тал.
НҮБ-ээс гаргасан “1996 оны дэлхийн хөгжлийн илтгэл”-ийн мэдээгээр 1994 онд Энэтхэг өмнөд Азийн бүс нутагт эзлэх жин, нөлөө нь: өмнөд Азийн нийт 1 тэрбум 220 сая хүн амын 74,9 хувь 914 сая, 4 сая 490 мянган км² газар нутгийн 73,3 хувь буюу 3 сая 290 мянган км², мөн өмнөд Азийн улсуудын дотоодын нийт 395 триллион ам. долларын 74,3% буюу 293,6 триллион ам.долларын бүтээгдэхүүнийг Энэтхэг үйлдвэрлэж байна. Мөн өмнөд Азийн 38,9 тэрбум ам.долларын гадаад худалдааны 64,3 хувь буюу 25 тэрбум долларын худалдааг Энэтхэг эзлэж байна.
4. Мөн тэнд 17-р тал
5. “1998\1999 оны Энэтхэгийн статистикийн товчоон” 1998 оны 12-р сар, 239-р тал. (хятад хэл дээр)
6. “Энэтхэгийн хөгжил хийгээд гадаад бодлогын стратеги” номын 139-р тал (хятад хэл дээр)
7. Мөн тэнд 141-р тал
8. Ван Яньмин “Даго дэ минюань” (“Их гүрнүүдийн хувь заяа”), Сычуаны ардын хэвлэлийн хороо, Чэнду, 2000, 254-р тал
9. Мөн тэнд 258-р тал
10. “Энэтхэгийн хөгжил хийгээд гадаад бодлогын стратеги” номын 141-р тал
11. “Их гүрнүүдийн хувь заяа” номын 258-259-р тал
12. Мөн тэнд 264-р тал
13. “Хуовань хайши дуйшоу (“Түншлэл үү эсвэл сөргөлдөөн үү”) Ерөнхий редактор Жан Вэньлин. Нийгмийн шинжлэх ухааны сурвалж бичгийн хороо, 2001, Бээжин. 530-р тал
14. “21 шици: шице гэцзю ю даго гуансы” (XXI зуун: дэлхийн байдал ба их гүрнүүдийн харилцаа). Ерөнхий редактор Жан Вэньмин, 2001, Бээжин, 156-р тал.
15. “Гошзы гуансы ю жунго вайшзю (Олон улсын харилцаа ба Хятадын гадаад бодлого) Бээжингийн радиогийн дээд сургуулийн хэвлэлийн хороо. Ерөнхий редактор Ли Шоюань Бээжин, 1999, 219-р тал